



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1.3 дахь заалт, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь, Улсын Их Хурлын 2022 оны 07 дугаар тогтоолын хавсралтын 5.1.2 дахь заалт, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар тогтоолын хавсралтын 4.10, 7.1.1 дэх заалт, Хурлын даргын 2025 оны 04 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтын 1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй шашинаас, сүмийн хийдийн үйл ажиллагаатай танилцаж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр хяналт, шалгалт хийх, зөвлөмж, чиглэл өгөх үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Чингэлтэй дүүргийн ИТХ-ын Төлөөлөгч, Эрх зүй, нутгийн удирдлагын хөгжлийн хорооны дарга

Гишүүд:

Чингэлтэй дүүргийн ИТХ-ын Төлөөлөгч, Эрх зүй, нутгийн удирдлагын хөгжлийн хорооны гишүүд

Чингэлтэй дүүргийн ИТХ-ын Ажлын албаны Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга

Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн ахлах байцаагч

Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн хяналтын байцаагч

Чингэлтэй дүүргийн Татварын хэлтсийн Татварын хяналт шалгалтын тасгийн улсын байцаагч

Чингэлтэй дүүргийн Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн эрүүгийн мөрдөгч

Чингэлтэй дүүрэг дэх Цагдаагийн хоёрдугаар хэлтсийн эрүүгийн мөрдөгч

Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн Хөдөлмөрийн хяналтын мэргэжилтэн, улсын байцаагч

Чингэлтэй дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн Хүүхдийн эрхийн улсын байцаагч

Чингэлтэй дүүргийн Боловсролын хэлтсийн суурь, бүрэн дунд боловсрол хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Чингэлтэй дүүргийн ИТХ-ын Ажлын албаны Хүний нөөц, шагнал хариуцсан мэргэжилтэн

2.Хяналт, шалгалтын удирдамжийг хавсралт ёсоор баталсугай.

3.Ажлын хэсгийн тайлан, мэдээг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлд танилцуулахыг Ажлын хэсэг (Д.Мөнхтөр)-т даалгасугай.

4.Ажлын хэсэг ажиллахад шаардагдах зардлын төсвийг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба (П.Баянбаатар)-нд зөвшөөрсүгэй.



Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын даргын 2025 оны ~~02~~-дугаар сарын ~~07~~-ны  
өдрийн ~~16~~ дугаар захирамжийн хавсралт

УДИРДАМЖ

## Хяналт шалгалт хийх тухай

Нэг.Зорилго

Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй сүм, хийдийн үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, санал, дүгнэлт боловсруулж, холбогдох байгууллагад танилцуулахад оршино.

Хоёр.Хяналт шалгалтын үндэслэл

2.1.Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах;

2.2.Иргэн, аж ахуй нэгж байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг барагдуулах;

Гурав.Хяналт шалгалтын чиглэл

3.1.Сүм хийдийн дүрэм, түүний нэмэлт өөрчлөлт хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх;

3.2.Сүм хийдийн байршил, үйл ажиллагаа, өмч, аж ахуйн харилцаа холбогдох хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаа эсэх;

3.3.Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хангаж байгаа эсэх;

3.4.Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, ард түмний уламжлал, зан заншилд харшлах болон хохирол учруулж болох үйл ажиллагаа явуулж байгаа эсэх;

3.5.Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа эсэх;

3.6.Үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлд заагдсан байршилд үйл ажиллагаа эрхэлж байгаа эсэх;

3.7.Сүм, хийдийн санхүүгийн эх үүсвэр хууль тогтоомжийн дагуу бүрдэж байгаа эсэх;

3.8.Бусад гэсэн чиглэлээр хяналт шалгалт хийж санал дүгнэлт гаргахад оршино.

**Дөрөв.Хяналт шалгалт хийх хугацаа**

Хяналт шалгалтыг 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрөөс 02 дугаар сарын 20-ны өдрүүдэд зохион байгуулна.

**Тав.Хяналт шалгалтын хүрээ**

Хяналт шалгалтад дүүргийн нутаг дэвсгэрт шашин, сүм, хийдийн үйл ажиллагаа эрхэлж буй бүх төрлийн шашны байгууллага хамаарна.

**Зургаа.Үр дүн**

Хурлын хороо, Ажлын хэсэг сүм хийдийн үйл ажиллагаатай газар дээр нь удирдамжийн дагуу танилцаж, санал, дүгнэлт гарган дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлд танилцуулсан байна.

**Долоо.Ажиллах хуваарь:**

№	Хугацаа	Цаг	Байгууллагын нэр	Хороо
1	2025.02.12 /Лхагва гараг/	09 <sup>00</sup> -09 <sup>30</sup> цагт	Дашдаржаалин хийд	24 дүгээр хороо
		09 <sup>30</sup> -10 <sup>30</sup> цагт	Есүс Христ	
		10 <sup>30</sup> -11 <sup>00</sup> цагт	Ариун салхит цуглаан	
		11 <sup>00</sup> -12 <sup>00</sup> цагт	Зүрх уул	
		13 <sup>00</sup> -14 <sup>00</sup> цагт	Зүрх уул амийн булаг чуулган	23 дугаар хороо
		14 <sup>00</sup> -15 <sup>00</sup> цагт	Есгүй тэнгэрийн өргөө холбоо	
		15 <sup>00</sup> -16 <sup>00</sup> цагт	Нэгэн хайр - Шинэ амь сүм	
		16 <sup>00</sup> -17 <sup>00</sup> цагт	Шулуун зам баптист	
2	2025.02.13 /Пүрэв гараг/	17 <sup>00</sup> -18 <sup>00</sup> цагт	Чингэлтэй амьд үг христийн цуглаан буюу үйлчлэл	20 дугаар хороо
		09 <sup>00</sup> -10 <sup>00</sup> цагт	Ивээлийн хүрээ	
		10 <sup>00</sup> -11 <sup>00</sup> цагт	Энхболд	
		11 <sup>00</sup> -12 <sup>00</sup> цагт	Есүсийн дагалдагч цуглаан	18 дугаар хороо
		12 <sup>00</sup> -13 <sup>00</sup> цагт	Жанчив дэнчилэн хийд	
		13 <sup>40</sup> -14 <sup>20</sup> цагт	21 дарь эхийн бодлын орон түлхүүр хийд	
		14 <sup>20</sup> -15 <sup>00</sup> цагт	Бэтээл сүм	

		15 <sup>00</sup> -16 <sup>00</sup> цагт	Давидын удам чуулган	17 дугаар хороо
		16 <sup>00</sup> -17 <sup>00</sup> цагт	Чингэлтэй Баптист чуулган	
3	2025.02.14 /Баасан гараг/	09 <sup>00</sup> -10 <sup>00</sup> цагт	Галдан Пунцаглан хийд	15 дугаар хороо
		10 <sup>00</sup> -11 <sup>00</sup> цагт	Ариун гэгээн сүм	
		11 <sup>00</sup> -12 <sup>00</sup> цагт	Хийд	14 дүгээр хороо
		12 <sup>00</sup> -12 <sup>40</sup> цагт	Гайхамшигт хайрын өргөө	13 дугаар хороо
		12 <sup>40</sup> -13 <sup>20</sup> цагт	Пунцагцогчинлин хийд	
		14 <sup>00</sup> -15 <sup>00</sup> цагт	Есүс Христийн хожмийн үеийн гэгээнтнүүд	
		15 <sup>00</sup> -16 <sup>00</sup> цагт	Чойжин Срунма	
		16 <sup>00</sup> -16 <sup>40</sup> цагт	Элиний ундарга	12 дугаар хороо
4	2025.02.17 /Даваа гараг/	16 <sup>40</sup> -17 <sup>30</sup> цагт	Чингэлтэйн нэгдсэн митодист	11 дүгээр хороо
		17 <sup>30</sup> -18 <sup>00</sup> цагт	"Цаглашгүй гэрэлт төв" ТББ	
		09 <sup>00</sup> -10 <sup>00</sup> цагт	Самъяа хийд	8 дугаар хороо
		10 <sup>00</sup> -11 <sup>00</sup> цагт	Халлелүүяа сүм	
		11 <sup>00</sup> -12 <sup>00</sup> цагт	Түвдэнпэдгээлин	5 дугаар хороо
		12 <sup>00</sup> -13 <sup>00</sup> цагт	Бадма ёга /Төв гандангийн харъяа/	
		14 <sup>00</sup> -15 <sup>00</sup> цагт	Зая гэгээний гүшог	
5	2025.02.18 /Мягмар гараг/	15 <sup>00</sup> -16 <sup>00</sup> цагт	Улаанбаатарын 7 дахь өдрийн Адвентист сүм	2 дугаар хороо
		16 <sup>00</sup> -17 <sup>00</sup> цагт	Бүтэв хийд	
		17 <sup>00</sup> -17 <sup>30</sup> цагт	Жавзандамба хутагт төв	
		09 <sup>00</sup> -10 <sup>00</sup> цагт	Ариун үндэст баптист	1 дүгээр хороо
		10 <sup>00</sup> -11 <sup>00</sup> цагт	Монголын рисшокосей-кай	
		11 <sup>00</sup> -11 <sup>40</sup> цагт	Их хөлөгний уламжлалыг хадгалах төв	
		11 <sup>40</sup> -12 <sup>30</sup> цагт	Есүс Христийн Хожмын үеийн гэгээнтнүүдийн сүм	